

САНАЛ ХУДАЛДАН АВАЛТЫН ЭСРЭГ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2026 оны 3 дугаар
сарын 20-ны өдөр

Улаанбаатар хот

Энэ хуулийн зорилт нь санал худалдан авах болон сонгогчдын саналд хууль бусаар нөлөөлөх бүх хэлбэрийг хориглох, урьдчилан сэргийлэх, олон нийтийн оролцоо, хяналтыг дэмжих, тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино. Хуулийн төсөл нь 5 бүлэг, 16 зүйлтэй.

Энэ хууль батлагдсан тохиолдолд санал худалдан авах зорилготой үйлдлийг сонгуулийн болон сонгуулийн бус жил гэж ялгахгүй хориглох үндэслэл бүрдэнэ. Сонгуулийн болон сонгуулийн бус үед төрийн санхүү, нөөцийг ашиглан сонгогчийн саналд нөлөөлөх асуудлыг таслан зогсоох нь авлигын урьдчилан сэргийлэх бодлогын хүрээнд хамаарах бөгөөд санал худалдан авах үйлдлийг хориглох, урьдчилсан сэргийлэх эрх зүйн бие даасан зохицуулалт шаардлагатай байгаа болно.

Хуулийн төсөлд иргэн, хуулийн этгээд нь санал худалдан авах хууль бус үйлдлээс ангид байх, түүнийг үл тэвчих, зөрчлийг мэдээлэх, хуульд заасан этгээд нь ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, урьдчилан сэргийлэх, зөрчил үүссэн тохиолдолд түүнээс татгалзах, санал худалдан авах үйлдэл хийсэн, оролцсон этгээдэд хууль зүйн хариуцлага гарцаагүй хүлээлгэх, сонгуульд нэр дэвшиж сонгогдсон этгээд санал худалдан авах гэмт хэрэг үйлдсэн нь хуулийн хүчин төгөлдөр шийдвэрээр тогтоогдсон бол түүний бүрэн эрхийг хугацаанаас өмнө дуусгавар болгох, эгүүлэн татах, огцруулах үндэслэл, зарчмыг тусгасан.

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр (2023–2030)” нь авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх эрх зүйн орчныг бэхжүүлэх, шударга ёсны засаглалыг төлөвшүүлэх зорилт дэвшүүлсэн. Уг хөтөлбөрийн зорилго нь “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлэх, үндэсний шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх замаар авлига, албан тушаалын гэмт хэргийг бууруулж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх эрх зүйн орчныг бэхжүүлэх, нийгмийн бүх түвшинд шударга ёсыг эрхэмлэсэн хандлагыг төлөвшүүлэн, шударга ёсны засаглалыг бэхжүүлэхэд чиглэсэн байна гэжээ.

Уг хөтөлбөрийн хүрээнд Улс төрийн хүрээнд авлигатай тэмцэх хүсэл зориг, хүчин чармайлт, манлайлал, ил тод байдлыг төгөлдөршүүлэх зорилгыг тэргүүн ээлжинд дэвшүүлсэн байна. Уг зорилгын хүрээнд:

Зорилт 1.2. Сонгуулийн бус үеэр санал худалдан авахад чиглэсэн бүх хэлбэрийг хориглоно.

1.2.1. Улсын Их Хурлын гишүүн, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч бүрэн эрхийнхээ хугацаанд иргэдэд мөнгө, эдийн болон эдийн

бус хөрөнгө, тэдгээрийг өмчлөх эрхийг шилжүүлэх, үнэ төлбөргүй, эсхүл хөнгөлөлттэй үйлчилгээ үзүүлэх, эдгээрийг амлах, санал болгох зэрэг бүх төрлийн санал худалдан авах үйлдэл гаргахыг хориглох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, хяналт, хариуцлагын тогтолцоог бүрдүүлнэ.

1.2.2.Төрийн улс төрийн албан тушаалтан иргэдийн саналыг авах зорилгоор сонгуулийн бус үед төрийн ажил, үйлчилгээг өөрийн нэрээр хэрэгжүүлэх, төрийн байгууллага, албан тушаалтныг хувийн ашиг сонирхлын үүднээс үйл ажиллагаандаа татан оролцуулах, мөнгө, эд зүйл тараахыг хориглоно.

1.2.3.Сонгогчийн саналыг худалдан авахыг завдсан, худалдан авсан, сонгуулийн зардлын тайлангаа үнэн зөв гаргаагүй хүн, хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалтыг бий болгож, хяналт, хариуцлагын тогтолцоог бүрдүүлнэ.

Зорилт 1.1.Сонгуулийн үеэр санал худалдан авахад чиглэсэн бүх хэлбэрийг хориглож, хариуцлага хүлээлгэх эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.

1.1.1.Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд сонгуулийн үеэр санал худалдан авахтай холбоотой гэмт хэрэг, зөрчлийг шалган шийдвэрлэх харьяалал, журмыг боловсронгуй болгоно гэж заажээ.

Хуулийн төсөлд “Санал худалдан авалт” гэж аливаа этгээд сонгогчийн саналд хууль бусаар нөлөөлөх зорилгоор өөрийн, гуравдагч этгээдийн, эсхүл улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө, нөөц, албаны эрх мэдлийг ашиглан иргэн эсхүл сонгогчдын тодорхой бүлэгт мөнгөн болон мөнгөн бус хэлбэрээр эдийн болон эдийн бус ашиг, давуу байдал олгох, амлах үйлдэл, үйл ажиллагааг ойлгохоор тусгасан.

Хуулийн төсөлд “Санал худалдан авах зорилготой гуравдагч этгээд” гэж улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигч, нэр дэвших сонирхол бүхий этгээдийн ашиг сонирхлын төлөө энэ хуулиар хориглосон үйл ажиллагааг санаатайгаар хэрэгжүүлж, зохион байгуулж, зуучилж, эсхүл бодит дэмжлэг үзүүлсэн аливаа этгээдийг ойлгохоор тусгасан.

Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллага, албан тушаалтан, бусад этгээдийн талаар:

Уг хуулийн үйлчлэлд хамаарах албан тушаалтан, этгээдийг дор дурдсан байдлаар тодорхойлсон. Үүнд:

- 1.Монгол Улсын Ерөнхийлөгч;
- 2.Улсын Их Хурал, Улсын Их хурлын дарга, гишүүн;
- 3.Засгийн газар, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн;
- 4.Бүх шатны иргэдийн Төлөөлөгчдын хурлын дарга, төлөөлөгч, ажлын албаны дарга, бүх шатны Засаг дарга, орлогч, Засаг даргын тамгын газрын дарга;

5.Төрийн улс төр, захиргаа, үйлчилгээ, тусгай албан тушаалд байнга, эсхүл үүрэг гүйцэтгэгч, гэрээгээр ажил, үүрэг гүйцэтгэгч, түр хугацаагаар томилогдсон буюу сонгогдсон албан хаагч;

6.Төрийн болон орон нутгийн өмчит, түүнчлэн төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, тэдгээрийн албан тушаалтан;

7.Улс төрийн нам, эвсэл, харъяа байгууллага, түүний сонгуульт гишүүн;

8.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын сонгууль, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд нэр дэвшигч;

Санал худалдан авалтыг хориглох, урьдчилан сэргийлэх талаар:

Хуулийн төсөлд санал худалдан авалттай холбоотойгоор хориглох үйлдэл, үйл ажиллагааг хуулийн төслийн 7 дугаар зүйлд тодорхойлон заасан. Энэ хуулийн төслийн 5.1-т заасан болон бусад аливаа этгээд өөрөө болон бусдаар дамжуулан санал худалдан авах болон сонгогчдын саналд хууль бусаар нөлөөлөх зорилгоор дараахь үйлдэл, үйл ажиллагаа явуулахыг хориглосон. Үүнд:

1.Мөнгө, эд зүйл, бараа үнэгүй тараах, хөнгөлөлттэй үнээр худалдах, эрх олгох, аливаа үйлчилгээ төлбөргүйгээр болон хөнгөлөлттэй үзүүлэх, эдгээрийг амлах;

2.Нийтийг хамарсан баяр наадам, урлаг, спорт, соёл, олон нийтийн арга хэмжээ, тоглолт, хүлээн авалт, цайллага, хонжворт сугалаа, төлбөрт таавар, бооцоот болон мөрийтэй тоглоом, эдгээртэй адилтгах бусад үйл ажиллагаа зохион байгуулах, ивээн тэтгэх, шагнах, урамшуулах, эдгээрийг амлах;

3.Гадаад, дотоодод аялуулах, амралт, сувилалд амруулах, эдгээрийг амлах;

4.Ирээдүйд мөнгө, эд зүйл, бараа өгөхөөр гэрээ байгуулах, хэлцэл хийх, амлалт, баталгаа гаргах;

5.Ажлын байрыг нь хадгалах, албан тушаалд томилох, томилуулах, дэвшүүлэх, зуучлах, өөрчлөх, эдгээрийг амлах;

6.Санал худалдан авалтыг нуун дарагдуулах зорилгоор бусдын нэр, данс, төлбөрийн карт, санхүүгийн бусад хэрэгслийг ашиглах;

7.Зээлийн болон бусад өр төлбөрийг тэглэх, хүчингүйд тооцох, хөрвүүлэх, хөнгөлөх, хэлбэрийг өөрчлөх, эдгээрийг амлах;

8.Улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмч, хөрөнгө, нөөц, эрх мэдлийг урвуулан ашиглаж зориулалтын бусаар зарцуулах;

9.Улсын болон орон нутгийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит этгээдийн ажилтан, албан тушаалтан, ажил, үйлчилгээ, эд хөрөнгө, нөөцийг ашиглах,

10.Иргэн, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээг үзүүлэх, үзүүлэхгүй байх, аливаа байдлаар дарамт, шахалт үзүүлэх, нөлөөлөх, хясан боогдуулах;

11.Улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчийн этгээдийн хөрөнгө, нөөцөөр хэрэгжүүлсэн ажил үйлчилгээ, барилга байгууламж,

төсөл, арга хэмжээний нээлт, ёслолын арга хэмжээнд оролцох, худалдан авсан машин, тоног төхөөрөмж, эд хөрөнгийг хүлээлгэж өгөх, тууз хайчлах зэргээр далд сурталчилгаа хийх, олон нийтийг төөрөгдүүлэх, нөлөөлөх;

12. Улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчийн этгээдийн төсөв, хөрөнгийг төрийн ажил, үйлчилгээг олон нийтэд хүргэхээс бусад зорилго, байдлаар хэвлэл мэдээлэл, сурталчилгаанд зарцуулах;

13. Төрийн болон орон нутгийн байгууллага, төрийн бус байгууллагын аливаа шагналыг олгох, тараах, зуучлах, амлах;

14. Хөнгөлөлттэй зээл, тэтгэлэг, буцалтгүй тусламж, тэтгэмж, төсөл, хөтөлбөрт иргэдийг хууль бусаар хамруулах, хамрагдахад дэмжлэг үзүүлэх, зуучлах, амлах;

15. Санал худалдан авалтын талаар мэдээлэл, гомдол гаргасан этгээдэд дарамт шахалт үзүүлэх, нэр хүндэд нь халдаж, илт худал мэдээлэл тараах;

16. Санал худалдан авалтыг аливаа хэлбэрээр дэмжих, зохион байгуулах, зуучлах, гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэхээр төлөвлөх, үүрэг даалгавар өгөх, гүйцэтгүүлэх, хамтран ажиллах;

17. Санал худалдан авалт зохион байгуулах, санхүүжүүлэх, халхавчлах зорилгоор хуулийн этгээд, Төрийн бус байгууллага, сан, хуулийн этгээд байгуулах, ашиглах;

Хуулийн төсөлд Улсын Их Хурал, Засгийн газар, түүний харьяа байгууллага, төрийн өмч, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, тэдгээрийн албан тушаалтан, бүх шатны Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, улс төрийн нам, эвсэл, хөдөлгөөн, намын гишүүний хүлээх нийтлэг үүргийг тусгав.

Улсын Их Хурал нь санал худалдан авалтын эсрэг улс төрийн хүрээнд санал худалдан авалттай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх талаар бодлого, зорилт дэвшүүлэн ажиллах, ээлжит сонгуулийн жилд сонгогчийн тодорхой бүлэгт шууд чиглэсэн, эсхүл нийтэд хамаарах мөнгөн олголт, халамж, тэтгэмж, татаас, хөнгөлөлт, урамшуулал, нэг удаагийн дэмжлэг, зээл болон зээлийн хөнгөлөлт, өр төлбөрийг тэглэх буюу чөлөөлөх арга хэмжээг шинээр бий болгох, арга хэмжээний хэрэгжилтийг эхлүүлэх, дүн, хэмжээг нэмэгдүүлэх чиглэлээр хууль тогтоомж санаачлах, хэлэлцэх, батлахыг хориглох талаар тусгав.

Хуулийн эдгээр хязгаарлалт нь хуульд урьдчилан заасан болон тогтмол хэрэгжиж байгаа мөнгөн олголт, халамж, тэтгэмж, нийгмийн хамгааллын арга хэмжээний хэвийн хэрэгжилтэд хамаарахгүй болохыг тусгасан.

Засгийн газар, яам, агентлаг, төрийн өмч, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, тэдгээрийн албан тушаалтан нь санал худалдан авалтын эсрэг ээлжит сонгуулийн жилд дараах агуулгатай захиргааны акт, шийдвэрийн төсөл санаачлах, хэлэлцэх, батлах, хэрэгжилт зохион байгуулахыг хориглох, сонгогчийн тодорхой бүлэгт шууд чиглэсэн, эсхүл нийтэд хамаарах бэлэн мөнгөн олголт, халамж, тэтгэмж, татаас, хөнгөлөлт, урамшуулал, нэг удаагийн дэмжлэг, зээл, зээлийн хөнгөлөлт, өр төлбөрийг тэглэх буюу чөлөөлөх арга хэмжээг шинээр бий болгох, улсын болон орон нутгийн төсөв, төсвийн тодотголд шинээр

тусгахаар санаачлах, нэмэгдүүлэх, арга хэмжээг хэрэгжүүлж эхлэхийг хориглох талаар тусгасан.

Хуулийн эдгээр хязгаарлалт нь хуульд урьдчилан заасан болон тогтмол хэрэгжиж байгаа мөнгөн олголт, халамж, тэтгэмж, нийгмийн хамгааллын арга хэмжээний хэвийн хэрэгжилтэд хамаарахгүй гэдгийг тусгасан.

Төсөлд иргэн нь санал худалдан авалт хийх санал болгохыг хориглох, санал худалдан авалтын аливаа үйлдэлд өртсөн бол заавал мэдээлэх талаар заасан.

Төсөлд санал худалдан авалтын эсрэг хууль тогтоомжийг зөрчсөн асуудлаар иргэн, хуулийн этгээд нь гомдол гаргах, аливаа этгээдээс холбоотой баримт бичиг, мэдээллийг гаргуулж авах, мэдэгдэл, байр сууриа илэрхийлэх эрхийг, энэ хуульд заасан санал худалдан авалттай холбоотойгоор иргэн, хуулийн этгээдийн мэдээлэл авах хүсэлтийн дагуу тухайн байгууллага, албан тушаалтан баримт бичиг, мэдээллийг гаргаж өгөх үүргийг заасан.

Төсөлд санал худалдан авалтаас урьдчилан сэргийлэхэд олон нийтийг төлөөлөх, олон нийтийн санал бодлыг сонсох, санал худалдан авалтын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар зөвлөмж гаргах үүрэг бүхий орон тооны бус олон нийтийн зөвлөлийг Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны дэргэд байгуулах, Олон нийтийн зөвлөл 25 гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд улс төрийн нам, иргэний нийгмийн төлөөлөл болох иргэнийг Төрийн байгуулалтын байнгын хорооны томилгооны сонсголоор 4 жилийн хугацаагаар томилж, Олон нийтийн зөвлөлийн ажиллах журмыг Төрийн байгуулалтын байнгын хороо батлахаар тусгав.

Төсөлд санал худалдан авах бүх хэлбэртэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар төрөөс баримтлах бодлого, зорилтыг Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгахаар тусгасан.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3.1.2 дахь хэсэгт заасан **"хувийн ашиг сонирхол** гэж нийтийн албан тушаалтан албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд өөрөө болон түүнтэй хамаарал бүхий этгээдийн зүгээс нөлөөлж болохуйц эдийн болон эдийн бус ашиг сонирхлыг" гэсэн ойлголтод **"санал худалдан авах ашиг сонирхлыг"** гэж нэмж, мөн хуулийн 3.1.11 дэх хэсэгт заасан **"ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал** гэж тухайн нийтийн албан тушаалтан өөрийн нэг ангид сурч байсан болон сурч байгаа этгээд, мөн гишүүнчлэлд нь хамаардаг холбоо, сан, хамтын шийдвэр гаргадаг байгууллага, тэдгээрийн гишүүд, нэг нутгийн хүн гэх зэрэг олон нийтийн зүгээс ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгохуйц этгээдтэй холбоотой асуудлаар үйл ажиллагаа явуулахыг" гэсэн гэдэгт **"санал худалдан авах зорилгоор үйл ажиллагаа явуулахыг"** гэж нэмж, уг хуулийн үйлчлэх хүрээнд санал худалдан авах үйлдэл, үйл ажиллагааг хамруулахаар төсөлд тусгав. Ингэснээр санал худалдан авах үйлдэл, үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ үр дүнтэй болно гэж үзэв.

Хариуцлагын талаар:

Санал худалдан авах үйлдэл нь эрх зүйн үр дагаварын хувьд нийгэмд аюултай үйлдэл, ноцтой хор уршигтай бөгөөд уг үйлдлийг Эрүүгийн хуулиар гэмт хэрэгт тооцохоор төсөлд тусгасан.

Эрүүгийн хуулийн Хоринхоёрдугаар бүлэгт Авлигын гэмт хэргийн тусгасан. Уг бүлгийн 22.14 дүгээр зүйлд Санал худалдан авах гэмт хэргийг шинээр тусгаж оруулсан. Үүнд:

22.14 дүгээр зүйл. Санал худалдан авах

1.Санал худалдан авалтын эсрэг хуульд заасан этгээд болон нийтийн албан тушаалтан, иргэн нь санал худалдан авах эсхүл сонгогчдын саналд хууль бусаар нөлөөлөх зорилгоор албан үүрэг, бүрэн эрх, боломж, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж Санал худалдан авалтын эсрэг хуулиар хориглосон үйлдлийг хийсэн бол нийтийн албанд ажиллах эрхийг хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар хасаж, нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Энэ гэмт хэргийг:

2.1.Сонгуулийн жилд;

2.2.Бүлэглэж;

2.3.Зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол нийтийн албанд ажиллах эрхийг дөрвөн жилээс найман жил хүртэл хугацаагаар хасаж, таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар: Санал худалдан авалтад оролцсон аливаа этгээд өөрийн санаачилгаараа санал худалдан авалтын талаар шүгэл үлээсэн, мэдээлэл, баримт ил тод болгосон бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6.1 дүгээр зүйлд Мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллагыг заасан бөгөөд Авлигатай тэмцэх байгууллага нь хуулийн төсөлд шинээр тусгасан Эрүүгийн хуулийн 22 дугаар зүйлийн 22.14 дэх хэсэгт заасан Санал худалдан авах гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулахаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулахаар тусгасан.

Сонгуульд нэр дэвшиж сонгогдсон этгээд санал худалдан авах гэмт хэрэг үйлдсэн нь шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр тогтоогдсон бол түүний бүрэн эрхийг хугацаанаас өмнө дуусгавар болгож, эгүүлэн татах, төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, тэдгээрийн албан тушаалтан, улс төрийн нам, эвсэл, түүний сонгуульд гишүүн нь санал худалдан авалт зохион байгуулсан, оролцсон, гуравдагч этгээдээр гүйцэтгүүлсэн, дэмжсэн бол хуульд заасан хариуцлага хүлээх үндэслэл болох талаар тусгасан.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3-т “Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ. Уул гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоовол Улсын Их Хурал түүнийг гишүүнээс нь эгүүлэн татна.” гэж заасан.

Өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж байгаа Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.6-д “Авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн нь шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор тогтоогдсон бол нэр дэвшихийг хориглоно.” гэж, УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.9-д “Авлига, албан тушаалтын гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон бол нэр дэвшихийг хориглоно.” гэж, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.8-д “Авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон бол нэр дэвшихийг хориглоно.” гэж тус тус заасан байна.

Хуулийн төсөлд тусгасан Санал худалдан авах үйлдэл нь авлигын гэмт хэрэгт хамаарах бөгөөд авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдсон тохиолдолд хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиар нэр дэвших эрхгүй юм.

Дагалдах хуулийн нэмэлт, өөрчлөлтийн талаар:

Ээлжит сонгуулийн жилд санал татах зорилготой хууль бус үйлдэл, үйл ажиллагааг хориглох талаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, Монгол Улсын их хурлын сонгуулийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэгт заасан байдаг. Эдгээр заалтыг Санал худалдан авалтын эсрэг хуулийн төсөлд тусгасан, энэ нь тохиолдолд санал худалдан авах зорилготой үйлдлийг сонгуулийн болон сонгуулийн бус жил ялгахгүй хориглох үндэслэл бүрдэж байгаа юм. Уг өөрчлөлттэй холбогдуулан дээр дурдсан хуулийн холбогдох зүйл, заалтыг хүчингүй болгохоор төсөлд тусгасан.

Мөн Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлд Сонгуулийн хууль зөрчих зөрчлийн талаар заасан бөгөөд уг зүйлийн 16 дахь хэсгийн 16.1-16.5 дахь хэсэгт санал татах зорилгоор хийсэн үйлдэлд Зөрчлийн хуулийн дагуу хариуцлага тооцохоор заасан. Зөрчлийн хуулийн уг заалтыг хүчингүй болгохоор төсөлд тусгаж, Эрүүгийн хуульд санал худалдан авах гэмт хэргийг тусгасан.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 14.5 дугаар зүйлд Иргэн сонгуулийн эрхээ эдлэх, сонгуулийн хорооны ажилд саад хийх гэмт хэргийг заасан бөгөөд уг зүйлийн 2 дахь хэсгийн 2.3-д сонгогчийг эд хөрөнгө, мөнгөөр татаж санал худалдан авч үйлдсэн бол гэмт хэрэгт тооцож ял шийтгэхээр заасан байдаг. Уг заалтыг хүчингүй болгохоор тусгасан.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд санал худалдан авах ашиг сонирхлыг тусгасан бөгөөд энэ нь худалдан авах ашиг сонирхолоос урьдчилан сэргийлэх, ашиг сонирхлын зөрчилтэй үйлдэл хийхгүй байх, ашиг сонирхлын зөрчлөөс татгалзах зэрэг ач холбогдолтой юм.

Улс төрийн сонгуульд орж сонгогдсон этгээд нь санал худалдан авах гэмт хэрэг үйлдсэн нь шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр тогтоогдсон тохиолдолд түүнийг эгүүлэн татах журмыг УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах байдлаар тусгав.

Энэ хуулийн төсөлтэй хамт хууль хоорондын уялдаа холбоог хангах үүднээс Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчийн хурлын сонгуулийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай болон Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулав.